



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/423

Булган сум

┌ Өрхийн үйлдвэрлэл, гар урлалын сургалт ┐  
зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4 дэх заалт, 42 дугаар зүйлийн 42.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах "Оргил мээж холбоо" нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон эцэг, эх, асран хамгаалагчид, зорилтот өрхийн иргэдэд өрхийн үйлдвэрлэл, гар урлалын сургалтыг зохион байгуулдаг бөгөөд энэхүү сургалтаа хэвийн үргэлжлүүлэхэд зориулж 2,000,000 (хоёр сая) төгрөгийн дэмжлэгийг тус холбоонд үзүүлсүгэй.

2.Дэмжлэгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6326010562